

УЛСЫН ИХ ХУРАЛ
Төсвийн тогтвортой байдлын зөвлөл



МОНГОЛ УЛСЫН 2024 ОНЫ НЭГДСЭН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ӨГӨХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот
2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “16¹.5.3. Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, улсын хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд дүгнэлт гаргах”, “7.1.3. Төсвийн тусгай шаардлагыг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг гаргах, тайлагнах, батлах үйл ажиллагаанд баримтална” гэсэн заалтуудыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны гүйцэтгэлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт гаргаж байна.

Зөвлөл дүгнэлт гаргахдаа Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан “Төсвийн тусгай шаардлага”-д нийцсэн эсэх, 7.3-т заасан “Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэснийг баримталсан эсэх, мөн Төсвийн тухай хуулийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна” гэж заасны дагуу тайлагнасан эсэхэд анхаарсан болно.

А. Макро эдийн засгийн бодлого, хуулийн хэрэгжилтийн хувьд

- 1. Төсвийн гүйцэтгэлийн үр дүн, үр ашгийн асуудал төсвийн төлөвлөлтөөс шууд хамааралтай байна.** Төсвийн тэлэлтийг хязгаарлах мөчлөг сөрсөн бодлого тууштай хэрэгжүүлэхгүй байгаа нь эрсдэл, хүндрэлийг нэмэгдүүлж байна. 2024 оны төсвийн гүйцэтгэлийг 30,591.1 тэрбум төгрөгөөр тайлагнасан нь ДНБ-ий 38.3 хувьтай тэнцэж байгаа бөгөөд төсвийг хэт тэлэх бодлого нь эдийн засаг дахь төрийн оролцоо, төсвийн эрсдэлийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна. 2024 оны 8 дугаар сард төсвийн тодотголыг өргөн барихдаа төсвийн тусгай шаардлагыг өөрчлөн төсвийг тэлэх орон зай бий болгож, төсвийн зарлагыг 3.0 их наяд төгрөгөөр нэмэгдүүлсэн. Хэдийгээр төсвийн тодотголыг өргөн барих хуулийн үндэслэл нь Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тухай асуудал байсан боловч үүнд хамааралгүй зардлуудыг тусгасан. Хэрвээ УИХ-ын зүгээс энэхүү тодотголын төслийг хэлэлцэхгүй буцаасан бол 2024 оны төсвийн зарлага 30 их наяд төгрөгт хүрч өсөхгүй, 2025 оны эхний баталсан төсөв 35 их наяд төгрөг болж тэлэхгүй, баталсан төсөвт Ерөнхийлөгч хориг тавих шаардлага үүсэхгүй, өнөөдөр эдийн засагт тулгарч буй сөрөг нөлөө, дарамт харьцангуй бага байх боломжтой байв.
- 2. Төсвийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах нь төсвийн тогтвортой байдлыг хангах, төсвийн гүйцэтгэл үр дүнтэй байх гол нөхцөл болно.** Төсвийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг алдагдуулж буй байдал нь а) Төсвийн тусгай шаардлагыг өөрчлөх, б) Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг баримтлахын оронд түүнийг төсөвт нийцүүлэн өөрчлөх, в) Хөгжлийн бодлого төлөвлөлтөд нийцээгүй хөрөнгө оруулалтыг төсөвт тусгах зэргээр илэрч байгааг цаашид онцгой анхаарахгүй бол төсвийн тогтвортой байдал, оновчтой бодлого, хөрөнгө оруулалтын үр дүнгийн талаар ярих боломжгүй болгож байна. Тухайлбал, Төсвийн хүрээний мэдэгдлийг тухайн жилийн төсвийн төсөлд нийцүүлэн өөрчилдөг байдал давтагдсаар байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хууль анх баталснаас хойш 18 удаа, 2025 оны 6 дугаар сарын 20-нд УИХ-д өргөн мэдүүлсэн Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тооцвол 19 удаа нэмэлт өөрчлөлт оруулж байгаа бөгөөд тодорхой заалтуудын хэрэгжилтийг удаа дараа хойшлуулж ирсэн. Тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх бус төсвийн хүрээний мэдэгдлийг жилийн төсөвтөө тааруулан өөрчилж байгаа асуудлыг ТТБЗ байнга сануулж,

ҮАГ удаа дараа албан шаардлага өгсөөр ирсэн боловч хэрэгжүүлэхгүй байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.10-т “дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл” гэж “тухайн төсвийн жилийн хүлээгдэж байгаа макро эдийн засгийн болон төсвийн гүйцэтгэлийн төлөв байдал, дунд хугацааны макро эдийн засгийн ба төсвийн үндсэн үзүүлэлтийн төсөөлөлд суурилсан төсвийн бодлогын баримт бичиг” (УИХ, 2010) хэмээн зааж бүтэц, агуулгыг нь тусгасан. Мөн хуулийн 10.1.3-т “төсвийн төсөл болон батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэх” гэж заасан байдаг.

Энэхүү заалтыг хэрэгжүүлэхгүй байгаагаас бодит байдалд “төсөв дагасан” Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг батлан, хэрэгжүүлж байгаа нь макро эдийн засгийн боломжийг хэтрүүлэн тооцсон төлөвлөлтийг өдөөх замаар төсвийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж, бодлогын эрсдэлийг бий болгож байна. Жишээ нь, 2024 оны төсвийн тодотголоор төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр тусгасан 342.6 тэрбум төгрөгийн зардал нь “Хөшгийн хөндийн туннелийн байгууламж”, “Өөдөө тэмүүлэх Монгол-Go Mongolia” ган татлагат гүүрэн байгууламж, “Шинэ тойрог зам”, Улаанбаатар хотын “Шинэ их тойруу” хурдны зам төсөл, “Харилцаа холбооны үндэсний хиймэл дагуул төсөл”, “Засгийн газрын нэг цэгийн үйлчилгээний цогцолбор” зэрэг төслийн зөвхөн урьдчилсан ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах, зөвлөх үйлчилгээ авах, бэлтгэл ажлыг хангах болон хөгжлийн бүтээн байгуулалтын төслүүдийн нэгдсэн менежментийн зөвлөх үйлчилгээний санхүүжилтэд зарцуулагдахаар тооцож байв.

Гэхдээ ихэнх шинэ төслийн эхлэх, дуусах хугацаа тодорхойгүйгээс гадна эдгээр төсөл Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсыг 2024 онд хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй юм. Энэхүү төсвийн тодотголын төсөлтэй хамт хөгжлийн бодлогын дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулах саналыг оруулаагүй нь төрийн захиргааны төв байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо сул байгааг харуулна. Түүнчлэн Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд зааснаар хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг нэн тодорхой, харилцан уялдаатай боловсруулж батлах, тэдгээрт тусгагдсан хөгжлийн зорилт, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, төсвийн эх үүсвэрийн тооцоог урьдчилан хийсэн байх, ТХМ-ийн төслийг боловсруулахын өмнө УИХ-аас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүд, томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг тооцсон байх ёстой. ҮАГ-ын дүгнэлтэд “Төсвийн төлөвлөлтөд улс төрийн нөлөө их байгаагаас урт хугацааны хөгжлийн бодлогын тогтвортой байдал алдагдаж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын гүйцэтгэл буурсан байна” хэмээн дурдсан нь үүний бас нэг нотолгоо юм.

- 3. Төсвийн бодлогын нийгэм, эдийн засгийн үр нөлөөг харгалзаж төсвийн гүйцэтгэлийг үнэлэх ёстой.** Төсвийн зарлагын энэ их тэлэлт Монгол Улсын эдийн засаг, нийгэмд ямар эерэг үр нөлөөг бий болгож байгааг тодорхойлох хэмжүүр алга байна. 2024 оны хувьд төсвийн төсвийн орлого, зарлагын өсөлт ихээхэн өндөр байсан боловч өмнөх онтой харьцуулахад эдийн засгийн өсөлт саарч 4.9 хувьтай гарсан. Эндээс төсвийн тэлэлт наад зах нь эдийн засгийн өсөлтийг дорвитой дэмжиж чадахгүй байгааг харж болно. Засгийн газрын өргөн барьсан төсвийн гүйцэтгэлийн танилцуулгын 1.8 буюу “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, хүрэх

үр дүнгийн тайлан” гэсэн хэсэг нь Төсвийн ерөнхийлөн захирагчдаар хөтөлбөрийн хэрэгжилт, хүрэх үр дүнгийн түвшнийг харуулж байгаа нь төсвийн гүйцэтгэлийн хэрэгжилтийг тодорхой хэмжээгээр илэрхийлж байна. Харин төсвийн бодлогын эдийн засаг, нийгмийн үр нөлөөг үнэлэхэд учир дутагдалтай байгааг анхаарч цаашид бодлогын нөлөөллийг хэмжих хэмжүүр бий болгож, түүнд үндэслэн төсвийн гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх шаардлагатай байна.

4. **Монгол Улсын төсвийн нэгдмэл байдлыг хадгалахад анхаарах шаардлагатай.** Төсвийн гүйцэтгэлийг УИХ-аар хэлэлцэхдээ нэгдсэн төсвийн асуудлыг авч үздэг. ҮАГ, ТТБЗ мөн нэгдсэн төсвийн төсөлд дүгнэлт гаргадаг. Мөн төсвийн гүйцэтгэлийг өргөн барихдаа нэгдсэн төсвийн хүрээнд буюу улс, орон нутгийн төсөв болон нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, баялгийн сан зэрэг нэгдсэн төсвийн бүрэлдэхүүний хамт өргөн барьдаг. Харин эцэст нь зөвхөн улсын төсвийг УИХ-аас баталж байгаа нь төсвийн нэгдмэл байдлын хувьд анхаарах асуудал юм. Жишээ нь, 2024 оны төсвийн гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт зарлагын УИХ-аас баталсан хэмжээ 30,487.9¹ тэрбум төгрөг, танилцуулгад дурдсан нэгдсэн төсвийн нийт зарлага 30,590.8 тэрбум төгрөг, нийт зарлага цэвэр зээлийн хэмжээ 33,595.3 тэрбум төгрөг байна. Энэ зөрүү нь ҮАГ-ын төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлтээс харахад орон нутгийн ИТХ бүрэн эрхийн хүрээнд Сангийн яамнаас хянасан төсвийн суурь зарлагын хязгаарыг 4,726.2 төгрөгөөр хэтрүүлсэнтэй холбоотой байна. Ингэснээр УИХ-аас баталсан нэгдсэн төсвийн зарлагын хэмжээнд орон нутгийн төсөвтэй холбоотой өөрчлөлт орж байгаа нь төсвийн нэгдмэл бодлогын хэрэгжилтэд нөлөөлж болзошгүйг анхаарах шаардлагатай.

Б. Төсвийн гүйцэтгэлийн талаар

5. **Төсвийн гүйцэтгэлд дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хангасан байдлын шинжилгээнээс үзэхэд хуулийн хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.** Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11.1.4-т “Төсвийн гүйцэтгэл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг хэрхэн хангасан байдалд дүн шинжилгээ хийх” хэмээх үүргийг санхүү, төсөв болон эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд тусгасан байдаг. Энэ заалт хэрэгжихгүй байгаагаас УИХ-аас баталсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн дагуу нэгдсэн төсвийн нийт зарлага, төсвийн бусад тоон үзүүлэлтүүд хангагдсан эсэх, макро эдийн засгийн бодлого хэрэгжсэн эсэхэд дүгнэлт хийх боломж хязгаарлагдаж байна. 2024 оны төсвийн нийт зарлагын дээд хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 31-нд анх батлагдахдаа ДНБ-ий 35.1 хувь, 2024 оны төсөв батлахад 37.0 хувь, 2024 оны 08 дугаар сарын 30-нд төсөв тодотгоход 38.5 болгож өөрчилсөн нь энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилт ямар байгааг илтгэх нэг хэмжүүр юм. Эдгээр тохиолдол бүрд тус баримт бичгийн бусад тоо баримт ч мөн адил өөрчлөгддөг бөгөөд энэ нь бодит байдалтай нийцтэй байсан эсэх болон эдийн засгийн бусад үр дагавар нь ямар байсныг үнэлж, дүгнэх асуудал орхигдож ирсэн. Цаашид энэхүү хуулийн заалтыг Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12-р зүйлд заасан агуулгын хүрээнд хэрэгжүүлэх нь төсвийн бодлогыг үнэлэх, хуулийн хэрэгжилтийг хангахад ихээхэн тустай болохыг зөвлөж байна.

¹ ҮАГ- Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Хүснэгт 1. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хэрэгжилт

№	Үзүүлэлт	ДХТХМ-д тусгагдсан	Гүйцэтгэл
1	ДНБ-ий бодит өсөлтийн хувь	5.6	4.9
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.5	9.0

6. **Төсвийн гүйцэтгэл одоогийн хуулийн хүрээнд төсвийн тусгай шаардлагыг хангаж байна.** 2024 оны 08 дугаар сарын 30-нд өөрчлөгдсөн төсвийн тусгай шаардлага, түүний хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнасан байна.

Хүснэгт 2. Төсвийн тусгай шаардлагын хэрэгжилт

№	Төсвийн тусгай шаардлага	Шалгуур	Хэрэгжилт
1	Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	2.0 хувь	2.1 хувь
2	Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь	30.0 хувь	27.7 хувь
3	Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь	60 хувь	41.8 хувь

Эдгээр үзүүлэлт төсвийн эрх зүйн орчны шаардлагыг хангаж байгаа нь харьцангуй зөв хандлага боловч энэ нь 2022-2024 оны эдийн засгийн таатай нөхцөл байдалтай уялдаатай, мөчлөгийн нөлөөлөлтэй гэдгийг анхаарах хэрэгтэй. Ялангуяа төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцоход ашиглаж буй үнийн түвшин нь Монгол Улсын гадаад худалдааны үнийг бодитойгоор илэрхийлж чадах эсэх нь цаашдын тэнцвэржүүлсэн орлогын биелэлт, баялгийн сангийн хуваарилалттай ихээхэн хамааралтай юм. Мөн 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр төсвийн тусгай шаардлагуудыг өөрчилснөөр 2024 оны төсвийн гүйцэтгэлээр төсвийн урсгал зардал ДНБ-ний 27.7 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн ДНБ-ний 38.3 хувьд хүрч 2023 оны дүнгээс 5.8 хувиар төрийн оролцооны түвшин нэмэгдэж байна. Мөн үүнтэй холбоотойгоор нэг жилийн дотор төсвийн зарлагыг 49.3 хувиар нэмэгдүүлж батлах боломж бүрдүүлсэн юм.

7. **Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн зарлагын хязгаарыг баримтлахгүй байдал хэвээр байна.** Нэгдсэн төсвийн нийт зарлагын хэмжээг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд зааснаас өндөр буюу 33,595.3 тэрбум төгрөгөөр тодотгон баталсан. Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн “7.3.Төсвийн төсөл боловсруулах, батлах, батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулахдаа дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ”, “5.1.3.төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлж, түүнд үндэслэн аль ч шатны төсвийн эрх захирагч нь төсвийн тусгай шаардлагыг хангасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслөө зохиох” гэсэн заалтуудтай нийцтэй бус байна.

Хүснэгт 3. ДХТХМ-ийн үзүүлэлт, төлөвлөлт, гүйцэтгэлийн байдал /тэрбум төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ДХТХМ-д тусгагдсанаар	Төсвийн төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ	30,487.9	33,595.3	30,591.0
2	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын доод хэмжээ	28,872.5	30,224.0	29,670.8
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	-1,615.4	-3,371.2	-920.0

Эндээс УИХ-аас баталсан Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл нь төсвийг дагаж өөрчлөгдөхөөс гадна бодит байдалд хэрэгждэггүй болох нь харагдаж байна.

8. **Хөрөнгө оруулалт, зээл тусламжийн гүйцэтгэлийг сайжруулах шаардлага хэвээр байна.** 2024 оны улсын төсөвт 3,828.6 их наядын төгрөгийн хөрөнгө оруулалт төлөвлөснөөс 3,093.5 тэрбум төгрөгийн санхүүжилт хийж, 80.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх жилүүдийн нэгэн адил доогуур дүн юм. Шаардлага хангаагүй, хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө оруулалтыг төсөвт тусгадаг нь үүнд нөлөөлж байна. Гүйцэтгэлийг задалж үзвэл шинэ хөрөнгө оруулалтын хувьд барилга байгууламж 53.5 хувь, их засвар 71.3 хувь, тоног төхөөрөмж 80.5, ТЭЗҮ 2.9 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын хувьд асуудал байгааг илэрхийлж байна. Мөн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 443.7 тэрбум төгрөг буюу 403.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөснөөс 333.8 тэрбум төгрөг буюу 303.7 хувиар давж биелсэн байна. Нэгдсэн төсвийн эргэж төлөгдөх дотоод цэвэр зээлийг 350.1 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 15.1 тэрбум төгрөг буюу 4.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь зээлийн төлөвлөлт гүйцэтгэл нь хэт зөрүүтэй байгааг илтгэж байна.

9. **Төсвийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийхэд машин сургалтын аргыг ашиглах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна.** Төсвийн тоонууд задгай буюу олон салбарласан, олон хувьсагчаас хамаарсан байдаг нь дүн шинжилгээ хийхэд хүндрэл учруулахаас гадна гүйцэтгэлээс дүгнэлт хийх, сургамж авах боломж олгохгүй байна. Нөгөө талаас гүйцэтгэл гэдэг нь өөрөө чанарын үзүүлэлт болж чадах давуу талтай учир орчин үеийн машин сургалтын “удирдлагатай сургалт” төрлийн арга техникийг ашиглах боломж харагдаж байна. Энэ хүрээнд 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлсийг шийдвэрийн мод үүсгэх алгоритмын тусламжтайгаар шинжилж, санхүүжилтийн төсөвт өртөгт эзлэх хувь тухайн ТЕЗ-ын хэрэгжүүлэх төслийн тооноос илүү чухал нөлөөтэй болохыг алгоритмаар тооцон харуулав (Зураг 1).


Доорх зургаас харахад хөрөнгө оруулалтын гүйцэтгэл амжилттай буюу 90%-аас дээш байхад:

- Санхүүжилт төсөвт өртгийнх нь 58.1%-аас багагүй байх;
- Санхүүжилт 58.1%-аас бага ч гэсэн тухайн ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын төслийн тоо 5-10-ын хооронд буюу цөөвтөр, гэхдээ хэт цөөн биш байх, эсвэл мөн тоо 50-100 хооронд байх;

Гүйцэтгэл тааруу буюу 27%-79%-тай байхад:

- Санхүүжилт төсөвт өртгийнх нь 51.8%-аас бага бөгөөд тухайн ТЕЗ-ын хөрөнгө оруулалтын төслийн тоо 0-5-ын хооронд буюу цөөн байх, эсвэл 10-50-ын хооронд байх, эсвэл 140-өөс их байхаар харагдаж байна.

Зураг 1. Улсын төсвийн 2024 оны гүйцэтгэлд нөлөөлсөн хүчин зүйлсийг машин сургалтын алгоритмтаар тооцсон байдал



УИХ төрийн эрх барих дээд байгууллага болохын хувьд төсвийн гүйцэтгэлийн хүрээнд баталсан бодлого, төлөвлөлт хэрхэн хэрэгжсэнийг бүрэн хянах шаардлагатай бөгөөд төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэн батлах үйл явцыг боловсронгуй болгох нь цаашдын төсвийн бодлого үр дүнтэй хэрэгжих гол урьдач нөхцөл болно.

ТӨСВИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ